
ТАНЫ ЭРХ ЗҮЙН МЭДЛЭГТ · 2026 оны 11-р сарын 13

ТАНЫ ЭРХ ЗҮЙН МЭДЛЭГТ: ГЭМТ ХЭРГИЙН ТАЛААРХ ГОМДОЛ, МЭДЭЭЛЛИЙГ ХЭД ХОНОГ ШАЛГАХ ВЭ?



Мөрдөгч гэмт хэргийн талаархи гомдол, мэдээллийг хянан үзээд гэмт хэргийн шинж байгаа эсэхийг тогтоох шаардлагатай бол гомдол, мэдээллийг хүлээн авснаас хойш 5 хоногийн дотор дараах мөрдөн шалгах ажиллагаа явуулж болно.

- Үзлэг хийх;

- Шинжилгээнд зориулж дээж, хурууны хээ, ул мөрний хэв авах;

- Хохирогч, гэрч, сэжигтнээс мэдүүлэг авах;

- Хэрэгт ач холбогдол бүхий тээврийн хэрэгсэл, мөнгө, эд зүйлийг хураж авах;

- Эд хөрөнгийг битүүмжлэх.

- Шинжилгээ хийлгэх шийдвэр гаргах.

Шаардлагатай тохиолдолд мөрдөн шалгах ажиллагаа явуулах албаны дарга энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан хугацааг нэг удаа 14 хүртэл хоногоор сунгаж болно.



Эх сурвалж: https://prosecutor.mn/post/455